



МОНГОЛ УЛС  
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2022 оны 07 сарын 22 өдөр


Дугаар А/475

Ховд

Хөрөнгө гаргах тухай

Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны 05/07 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. "Олон үндэстэн ястны өв соёл" хөтөлбөрийн 4.1 дэх (соёлын биет бус өвийг судлан сурталчлах, өвлүүлэн уламжлуулах арга хэмжээг зохион байгуулж, соёлын аялал жуулчлалыг хөгжүүлнэ) зорилтын хүрээнд "Урианхай, Тува түмний соёлын өдрүүд, Дөрвөд угсаатны өв соёлын анхдугаар наадам" арга хэмжээний зардалд 6,000,000 төгрөгийн дэмжлэгийг хавсралтаар баталж, зарцуулсугай.
2. Зардалд зарцуулагдах 6,000,000 төгрөг (зургаан сая)-ийг Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2022 онд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл арга хэмжээний 4.4 дэх Соёлын салбарын дэд хөтөлбөрүүд ("Олон үндэстэн ястны өв соёл") хөтөлбөр, төслөөс тооцож гаргахыг аймгийн Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (Ч.Багдал)-д зөвшөөрсүгэй.
3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (Т.Дэлгэрсайхан)-д даалгасугай.



Б.ДҮГЭРЖАВ

8400\_01\_2480  
Zah A/475 tum

Аймгийн Засаг даргын 2022 оны  
07 дугаар сарын 22-ны өдрийн  
А/475 дугаар захирамжийн хавсралт



### ӨВ СОЁЛЫН АРГА ХЭМЖЭЭНИЙ ЗАРДЛЫН ТӨСӨВ

дд	Арга хэмжээний нэр	Нэг бүрийн үнэ	Нийт үнэ
1	Урианхай, Тува түмний соёлын өдрүүд.	1000000	1000000
2	Дөрвөд угсаатны өв соёлын анхдугаар наадам	5000000	5000000
	Дүн		6000000

-oOo-